



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

### Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг шинэчлэн бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Хаан даатгал” ХХК-ийн “Эмчилгээний зардлын даатгал”-ын бүтээгдэхүүнийг хавсралтад дурдсаны дагуу шинэчлэн бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Хаан даатгал” ХХК /Л.Оргил/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 1-д заасан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Хаан даатгал” ХХК /Л.Оргил/-д анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн  
190 дүгээр тогтоолын хавсралт

Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Хаан даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Эмчилгээний зардлын даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал
4.	Даатгалын зүйл	2.6.3.1 Монгол Улсын иргэн; 2.6.3.2 Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаад улсын иргэн
5.	Даатгалын эрсдэл	Үндсэн хамгаалалт: 2.2.1 Даатгалын хамгаалалтын багцад заасан өвчлөл; 2.2.2 Архаг хууч өвчин; Нэмэлт хамгаалалт: 2.2.3 Жирэмслэлт, төрөлт; 2.2.4 Хавдар.
6.	Даатгалын гэрээний хугацаа	1 жил
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	4 бүлэг, 335 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	“Хаан даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/21 тоот тушаал
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Ц.Ган-Эрдэнэ
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Г.Мягмаржаргал